



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.2, 6.2.4, 6.2.5, 6.4.3, 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-109/15, 2021 оны 01-017-109/16 дугаар актаар тус тус тогтоогдсон, нийт 2,761,095,661.00 (хоёр тэрбум долоон зуун жаран нэгэн сая ерэн таван мянга зургаан зуун жаран нэгэн) төгрөгийн балансын үнэ, 382,147,076.43 (гурван зуун наян хоёр сая нэг зуун дөчин долоон мянга далан зургаан төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Дотоод хэргийн их сургуулийн захирал П.Батбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийн газар /чөлөөлөгдөх талбай/-ыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001098

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 0/ дугаар сарын 2- ны өдрийн
№ дүгээр тогтоолын хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, байршил	Ашиглалтад орсон, бүртгэсэн он (дахин үнэлгээгээр)	Хэмж их нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, бүртгэлийн үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1.Барилга байгууламж								
1	Хичээлийн 2-р байр	1978/2018	ш	5600	1,984,889,221.00	1,984,889,221.00	258,898,593.96	1,725,990,627.04
2	Хичээлийн 4-р байр /цэцэрлэг/	1978/2018	ш	1707	614,981,341.00	614,981,341.00	54,263,059.56	560,718,281.44
3	Вакум цонх	2008/2018	ш	287	119,243.00	34,222,741.00	30,990,593.39	3,232,147.61
4	Хүзүүвч	2009/2018	ш	210	69,638,358.00	69,638,358.00	13,927,671.72	55,710,686.28
	Дүн				2,703,731,661.00	2,703,731,661.00	358,079,918.63	2,345,651,742.37
2.Нийтийн эзэмшлийн хөрөнгө								
1	Хилийн сургуулийн талбай	2018	м2	1600	24,712.50	39,540,000.00	6,243,157.80	33,296,842.20
2	Бохир усны гадна шугам	1978/2018	м	1	17,824,000.00	17,824,000.00	17,824,000.00	0.00
	Дүн				57,364,000.00	57,364,000.00	24,067,157.80	33,296,842.20
	Нийт дүн				2,761,095,661.00 (хоёр тэрбум долоон зуун жаран нэгэн сая ерэн таван мянга зургаан зуун жаран нэгэн төгрөг)	2,761,095,661.00 (хоёр тэрбум долоон зуун наян хоёр сая нэг зуун дөчин долоон мянга далан зургаан төгрөг)	382,147,076.43 (гурван зуун наян хоёр сая нэг зуун дөчин долоон мянга далан зургаан төгрөг)	2,378,948,584.57 (хоёр тэрбум гурван зуун далан найман сая есөн зуун дөчин найман мянга таван зуун наян дөрвөн төгрөг тавин долоон мөнгө)